Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ СҮХЭЭГИЙН ОТГОНЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. “САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Хяналтын чиглэлийн 10.2.1, 10.2.2, 10.2.3, 10.2.4, 10.2.5, 10.2.6 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Шинэчилсэн хяналтын хуудасны тоо | ЭМС-ын 2023 оны А/78 дугаар тушаал | 6 | Хяналтын чиглэлийн 10.2.1, 10.2.2, 10.2.3, 10.2.4, 10.2.5, 10.2.6 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлуулан, шилэн хяналтын цахим системд суурилуулсан болно. | 2024.01-2024.03 | 100 |
| **ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 2.1. Улсын хэмжээнд эм хангамжийн 30 байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна. | Объектын хамралтын хувь | 80% | 90% | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 10.3.1 кодтой Эмийн сангийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудасны хамаарах асуудлын хүрээнд 30 эмийн сангийн эрсдлийг үнэлэхэд 15 буюу 50% нь бага эрсдэлтэй, 9 буюу 30% нь дунд эрсдэлтэй, 6 буюу 21.4% их эрсдэлтэй үнэлэгдсэн бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 71% байна.<br>Шалгалтад хамрагдсан эмийн сангуудад эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй 145 зөрчил, дутагдал илрүүлсэнээс 63%-ийг арилгуулан, 20 байгууллагад 123 заалт бүхий улсын (ахлах) байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, 2 байгууллагад 1.500.0 төгрөгийн шийтгэвэр ногдуулсан. | 2024.02.15--2024.09.15 | 100 |
| | | Эрсдэлийн түвшин | Их-30%<br>дунд-30% | | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 63.4% | | Хамралт 100%, хууль тогтоомжийн хэрэгжилт 71% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэд арга хэмжээ 2.1. Төлөвлөгөөт шалгалтын хамтарсан удирдамжийг боловсруулан, батлуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалтыг улсын хэмжээнд эхлүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | [illegible]% | Шалгалтын удирдамжийг боловсруулан батлуулж, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.<br>Шалгалтын дүнг хяналт хуудас, хавсралт хүснэгтийн хамт нэгтгэн, танилцуулга бичиж, ЭЭХХЗГ-т хүргүүлсэн. | 2024.02.05-2024.02.15 | 100 |
| 2 | Арга хэмжээ 2.2 Эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх | Объектын хамралтын хувь<br>Эрсдэлийн түвшин<br>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 91%<br>их-30%<br>дунд-63%<br>64,9% | 90% | СХГ-ын даргын баталсан 10-00/11 тоот удирдамжийн дагуу 18 /УБ хотод 8, Сүхбаатар-6, Архангай-4/ эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийн, эрсдлийг үнэлэхэд их эрсдэлтэй 2/11%/, дунд эрсдэлтэй 13/,72%/ бага эрсдэлтэй 3/16%/ эмнэлэг үнэлэгдэж, 18 эмнэлэгт 266 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллалаа.<br>Шалгалтын явцад ЭХЭМҮТ, УХТЭ, ЦССҮТ, Хүрээ амаржих газарт шинжилгээтэй хяналт хийн арчдасны 100, ариун материалын 32, агаарын 10, эмчилгээний хоолны 26 дээж авч, ХАБҮЛЛ-т шинжлүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн улсын ахлах байцаагчийн дүгнэлт бичиж хүргүүлсэн.<br>Архангай, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарт улсын ахлах байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажиллалаа.<br>Төлөвлөгөөт шалгалтын дүнг нэгтгэн, шалгалтын ахлахад хүргүүлэн ажиллалаа. | 2024.02.05-2024.10.15 | 100 |
| | Дэд арга хэмжээ 2.2.1 Сүхбаатар аймгийн 6 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдалд хяналт шалгалт хийнэ | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 20% | 70% | Салбарын хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 10-00/42 дугаартай "Төлөвлөгөөт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан, Сүхбаатар, сумын 6 эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийхэд их 1, дунд 1, бага 1 эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн.<br>Сүхбаатар аймгийн Засаг даргад болон 6 эмнэлэгт нийт 115 заалт бүхий улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийн байдалд хяналт | 2024.04.29-2024.05.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийхэд албан шаардлагаар өгсөн үүргийн хэрэгжилт 78% хэрэгжилттэй байна. | | |
| | Дэд арга хэмжээ 2.2.2 Улаанбаатар хотод зарлагдсан 8 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 20% | 70% | СХГ-ын даргын баталсан 10-00/11 дугаартай удирдамжийн дагуу ЭНЭМҮТ-2, ЦССҮТ, Эмгэг судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Хүрээ амаржих, ЭХЭМҮТ, УХТЭ, ГССҮТ эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийн, 10.2.1, 10.2.3, 10.2.4, 10.2.6 хяналтын хуудсуудаар үнэлгээ хийхэд, их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 6, бага эрсдэлтэй 1 эмнэлэг тус тус үнэлэгдсэн. 8 эмнэлэгт 108 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн. Шалгалтын явцад арчдас 100, ариун материал 12, агаарын 10, эмчилгээний хоолны 26 дээж авч, ХАБҮЛ-д шинжлүүлэн, дүнг үндэслэн дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтэд хяналт хийхэд, хэрэгжилт 75%-тай байна. | 2024.02.05-2024.10.15 | 100 |
| 3 | Арга хэмжээ 2.3. Шүдний тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт зохион байгуулна. | Хамралтын хувь | - | 50% | Эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэлээр хамрагдвал зохих 241, хамрагдсан 229, хамралт-95% Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр шалгалтад хамрагдсан эмнэлгийн 63%-д нь эрүүл зүйн хими, нян судлалын шинжилгээтэй хяналт хийж, үзлэг эмчилгээний өрөөний агаарын 195, ариун материалын 274, арчдасны 1423, өрмийн төхөөрөмжийн болон унд ахуйн усны 102, халдваргүйжүүлэх бодисын 23 дээжийг тус тус авч аймаг, нийслэлийн Стандарт хэмжил зүйн газар, хэлтсийн харьяа лабораторид шинжлүүлэн, шинжилгээний дүнгийн тухай 164 дүгнэлт бичиж шүдний эмнэлгүүдэд хүргүүлсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 2097 заалт бүхий 322 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтэд хяналт тавин ажиллалаа. | 2024.05.15-2024.10.15 | 100 |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 35 аж ахуйн нэгж байгууллага, иргэнд 45.400.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж зөрчлийн хэрэг бүртгэлийн материалыг аймаг, нийслэлийн Прокурорын газарт хүргүүлэн, Зөрчлийн үр дагаврыг арилгуулах тухай Эрх бүхий албан тушаалтны албан даалгавраар хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулан ажиллалаа. Гүйцэтгэлийн хяналтыг 195 шүдний эмнэлэгт хийхэд албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт дунджаар 82.3%-ийн хэрэгжилттэй байна. | | |
| 4 | Арга хэмжээ 2.4 Өрхийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулна. | Хамралтын хувь | - | 50% | Өрхийн эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн төсөл боловсруулан, СХГ-ын даргын 2024 оны 02 сарын 05-ны өдөр батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад Эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэлээр хамрагдвал зохих 138 Өрхийн эрүүл мэндийн төвөөс 125 буюу 90 хувь хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 161 эмнэлэгт нийт 1429 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөгдөж, Шимбилэг, Үүрийн мандах гэгээ, Конвер, Эрдэнэ энхсаран, Раушан ӨЭМТ-үүдэд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 6500.0 мянган төгрөгийн торгох шийтгэл ногдуулан, 38 заалт бүхий албан даалгавраар хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулсан. Гүйцэтгэлийн хяналтыг 135 өрхийн эрүүл мэндийн төв хийж, албан шаардлагын биелэлт дунджаар 78 хувьтай байна. Албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллаагүй Хан-уул дүүргийн 24 хорооны Эрдэнэ Энхсаран, Сонгинохайрхан дүүргийн 37 хорооны Отгон долоон бурхан Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Зөрчлийн тухай хуулийн | 2024.02.15-2024.05.15 | 100 |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 15.2 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг үндэслэн 2.000.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 100 хувь барагдуулсан.<br>Шалгалтын дүнг нэгтгэн газрын удирдлагад танилцуулж, нийслэлийн 8 дүүргийн Засаг дарга, Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоонд албан бичгээр санал хүргүүлсэн. | | |
| 5 | Арга хэмжээ 2.5 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага, стандартын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт зохион байгуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 50% | СХГ-ын даргын 2024 оны 02 сарын 08-ны өдөр баталсан 10-00/18 дугаартай удирдамж "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийн байдалд хийсэн төлөвлөгөөт бус шалгалтын дүнг нэгтгэн, удирдлагад танилцуулсан.<br>Тус шалгалтад төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалтад хамрагдсан нийт 360 эмнэлэг (Төв эмнэлэг, амаржих газар-14, БОЭТ, нэгдсэн эмнэлэг-19, Сумын эрүүл мэндийн төв-43, ӨЭМТ-78, клиник-202, сувилал-4, клиник-47) хамрагдсан.<br>"Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилт шалгагдсан үзүүлэлтийн хувьд 29,1 хувьтай байна. | 2024.02.15-2024.09.15 | 100 |
| | | | | | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартын хэрэгжилтийн хувь 39.1 хувьтай байна.<br>Нийт 959 заалттай 229 албан шаардлага, 12 заалттай 26 зөвлөмж хүргүүлсэн байна. | | |
| 6 | Арга хэмжээ 2.6 Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Удирдлагаас өгсөн үүргийн дагуу 60, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу 6, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 144 албан бичиг /хариутай 102/ хүсэлтийг хүлээн авч, хугацаанд нь 100% шийдвэрлэн ажилласан. Үүнд:<br>Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Ай Си Юу, Өрнөх эрүүл жаргал, Хүрээ амаржих, Амрида мед, ЭХЭМҮТ, ЭНЭМҮТ-2 зэрэг байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 26 зөрчил, дутагдал илрүүлэн, 19%-ийг газар дээр нь арилгуулж, илэрсэн дутагдлыг үндэслэн Ай Си Юу эмнэлэгт ЗТХ-ийн холбогдох заалтын дагуу | Тухай бүр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.000.0 төгрөгийн торгох шийтгэл ногдуулан, 8 заалт бүхий албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, биелэлтэд хяналт тавин ажилласан.<br>Мөн удирдлагаас өгсөн үүргийн дагуу НЭМГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн байгууллагад Тусгай зөвшөөрөл олгох комиссын үйл ажиллагаа, Хүрээ амаржих, Агапэ христийн эмнэлэг, Од марал Өү Ди Си ХХК-ийн Ай Си Си, Тэргүүн жаа ХХК-ийн Элледентал, Энхлэн, Лайф ворлд ХХК-ийн эмийн сан, Монос, Интермарко ХХК, Очирт сэлэнгэ мөрөн ХХК, Амин хүслэн фарм ХХК)-ийн эмнэлэгт тус тус зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, 6.500.0 мянган төгрөгийн торгох шийтгэл ногдуулан, ЭБАТ-ны албан даалгавраар хугацаатай үүрэг өгч ажилласан. | | |
| 7 | Арга хэмжээ 2.7 Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 20% | 70% | Барилгын ажлын зураг төсөлд хяналт хийлгэхээр ирүүлсэн 17 албан бичгийг хүлээн авч, СХГ-ын даргын баталсан 10-00/02 тоот удирдамжийн дагуу 60 боть зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж, Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийсэн тухай улсын ахлах байцаагчийн 14 дүгнэлт бичиж хүргүүлсэн.<br>Зураг төсөл, баримт бичгийн бүрдэл дутуу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүсэлтэд 3 аж ахуйн нэгж байгууллагад албан бичгээр хариу хүргүүлсэн. | 2024.02.05-2024.12.05 | 100 |
| 8 | Арга хэмжээ 2.8 Иргэн, ААН-ийн хүсэлтээр хяналтын чиглэлд хамаарах түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Шийдвэрлэлтийн хувь | - | 100 | Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу ХӨСҮТ, НЭМҮТ, 5 ААН-ийн хүсэлтээр цусны ийлдэс, цусны сийвэн, шээсний сорьцыг АНУ, БНСУ, Австрали, ХБНГУ руу илгээх нийт 68 дүгнэлт гаргасан. Үүнд: НЭМҮТ-д судалгааны зорилгоор Герман улсруу илгээх сорьцны 1, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагад БНСУ, ХБНГУ руу допингийн шинжилгээний зорилгоор илгээх /шээсний/ сорьцны 55, Ливэр центр ХХК-д судалгааны зорилгоор АНУ, БНСУ руу илгээх /цус, шээс, сийвэнгийн/ 2, Реженератив медикал сентр | Тухай бүр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХХК-д оношилгооны зорилгоор БНСУ руу илгээх /цусны/ 2, Си Эл Дабль Ю Эйч ХХК-д оношилгооны зорилгоор БНСУ руу илгээх /цусны/ 4, ХӨСҮТ-д судалгааны зорилгоор Япон, Австрали улс руу илгээх /цусны/ 2, Монголын Натурал Бодибилдингийн фитнессын холбоонд АНУ улсруу илгээх /шээсний/ шинжлэгдэхүүний 1 дүгнэлт гаргасан байна.<br>Буцаасан болон шийдвэрлээгүй хүсэлт байхгүй. | | |
| 9 | Арга хэмжээ 2.9 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээг НЭМГ-тай хамтарч хийнэ. | Үнэлгээний тайлан | - | 50% | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн бэлэн байдалд хийх үнэлгээний ажлын удирдамж боловсруулан батлуулж, "Жагсаалт батлах тухай" ЭМС-ын 2023 оны А/211 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, оношлуурын бэлэн байдалд үнэлгээ хийн ажиллалаа.<br>ЗӨСҮТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахад хадгалагдаж байгаа нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийхэд хамгаалах хувцас хэрэгслийн нөөцөд нэг удаагийн комбинзон 23379 ш, нэг удаагийн халад 3872 ширхэг, цогцос хадгалах уут 67, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцөд кальцийн гипохлорид 10тн, клорсепт 100 фл, аниозим прайм 125 фл, скинмэн софт 100 фл нөөцтэй байна.<br>Энэ нь ЭМС-ын 2023 оны А/211 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан 44 нэрийн эм, 36 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 8 нэрийн хувийн хамгаалах хэрэгсэл, 7 төрлийн тоног төхөөрөмж, 3 нэрийн ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлээгүй байна.<br>Үнэлгээний дүнг нэгтгэн, НЭМБГ-т хүргүүлсэн. | 2024.02.15-2024.12.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 3. "УЛСЫН БАЙЦААГЧДЫН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛНА" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1 "2024 оны төлөвлөлт, хяналт шалгалт хийх арга зүй" сургалт зохион байгуулна. | Сургалтын тайлан | - | сургалт хийсэн байна. | "2024 оны төлөвлөлт, хяналт шалгалт хийх арга зүй" сэдэвт сургалтыг 2024 оны 2 сарын 14-нд зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>"Шүдний эмнэлгүүдэд хийх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад анхаарах асуудал" сэдвээр Халдвар судлалын асуудал хариуцсан улсын /ахлах/ байцаагчдад 2024.05.17-ны өдөр цахим сургалт зохион байгуулсан.<br>Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах зааврын төслийг "Улсын байцаагчдын зөвлөгөөн"-өөр хэлэлцүүлж, аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчдаас ирүүлсэн саналыг нэгтгэсэн. | 2024.02.14-2024.12.05 | 100 |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| 1 | Арга хэмжээ 1. Эмнэлгийн орчинд тархсан тэсвэржилттэй нянгийн байдалд тандалт судалгаа хийх | | 50% | Дээж авч, эмнэлзүйн лабораторид шинжлүүлэх | УХТЭ, ГССҮТ, Мөнгөнгүүр, Грандмед эмнэлгүүдэд 2022-2023 онд хийгдсэн Өвдөг, түнхний үе солих мэс заслын дараах шархны халдварын зарим асуудлыг судлах нь судалгааны ажлын хэсэгт ажиллан, өвдөг, түнхний үе солих хагалгааны мэс заслын дараах шархны халдварын эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, антибиотикийн хэрэглээг үнэлэх талаар тандалт судалгаа хийн, Монголын тархвар судлаачдын зөвлөгөөнөөр хэлэлцүүлсэн.<br>Мөн судалгааны ажлыг НЭМГ-ын Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хэвлэлтэд хүргүүлсэн. | 2024.04.15-2024.12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 2. Мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | - | 1-ээс доошгүй | 1. ЗӨСҮТ-өөс зохион байгуулсан "Зоонозын өвчний чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах нь", Ариун холбоо ТТБ-аас зохион байгуулсан "Ариутгал халдваргүйтгэлийн сургагч багш бэлтгэх" сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.<br>2. ЭМЯ болон бусад төрийн байгууллагуудаас хамтран зохион байгуулсан "Авлигын эсрэг хууль", "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх тохиолдсон үед арга хэмжээ", "Төрийн бүтээмжийн сэргэлт – Цахим эрүүл мэнд", "Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн", "Цахим системд эрсдлийн шалгуур хяналтын хуудас угсрах", Улсын байцаачдын зөвлөгөөн болон зэрэг нийт 14 удаагийн сургалтад хамрагдсан.<br>3. ЭМЯ, ХӨСҮТ-өөс хамтран зохион байгуулсан Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, халдварын сэргийлэлт хяналтын сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдан, гэрчилгээ авсан. | 2024.01.15-2024.12.05 | 100 |
| 3 | Арга хэмжээ 3. Нэмэлт ажлууд | Үүрэг даалгаврын биелэлт | - | 100% | ТНБД-ын баталсан 2024 оны А/10 дугаар тушаалын дагуу Цагаан сарын баярын үеэр хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж, мэдээ нэгтгэн бичиж, хяналт тавих албан тушаалтанд танилцуулсан. | 2024.02.09-2024.02.13 | 100 |
| | | | | | 2023 оны төлөвлөгөөт шалгалтын дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цаашид авах арга хэмжээний саналыг нэгтгэн, 2024.04.24-ний өдрийн 2/1691 тоот албан бичгээр Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | 2024.03.05-2024.04.15 | 100 |
| | | | | | ТНБД-ын баталсан төлөвлөгөөний дагуу "Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтаны зөвлөгөөн" "Эмч тандаа баярлалаа-2024", "Сувилагч танаараа бахархъя-2024" арга хэмжээний зохион байгуулалтын ажлын хэсэгт ажилласан. | 2024.03.29-2024.05.15 | 100 |
| | | | | | "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, | 2024.02.05-2024.05.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тээвэрлэх, боловсруулах, устгах зааврыг шинэчлэн батлах тухай" ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаалыг өөрчлөх ажлын хэсэгт ажилласан. | | | |
| | | | | Дотоод ажил үүргийн хуваарийн дагуу аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчдын хяналт шалгалтын тоон мэдээллийг эхний хагас жилийн байдлааар нэгтгэн гаргасан. | 2024.05.15-2024.05.31 | 100 |
| | | | | Эрүүл мэндийн байгууллагын төвлөрлийг сааруулах, лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хэсэгт ажиллан, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг, Өмнөговь аймгийн БОЭТ-д тус тус ажиллан, илтгэх хуудсыг ажлын хэсгийн ахлахад хүргүүлсэн. | 2024.09.03-2024.10.16 | 100 |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч ................................ /С.Отгонжаргал/ 2024.12.05.

(*Албан тушаал*) *Нэр, гарын үсэг*) (*Огноо*)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Салбарын хяналтын газрын дарга .................................... / О.Энхболд / ..................................

(*Албан тушаал*) (*Нэр, гарын үсэг*) (*Огноо*)

8

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ СҮХЭЭГИЙН ОТГОНЖАРГАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭМЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эхний хагас жил | сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | **Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Хяналтын чиглэлийн 10.2.1, 10.2.2, 10.2.3, 10.2.4, 10.2.5, 10.2.6 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Шинэчилсэн хяналтын хуудасны тоо | ЭМС-ын 2023 оны А/78 дугаар тушаал | 6 | - | 01 | 02 |
| | **Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 2.1**. Улсын хэмжээнд эм хангамжийн 30 байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна. | Объектын хамралтын хувь | 80% | 30% | 70% | 02 | 10 |
| | | Эрсдэлийн түвшин | их-30% дунд-30% | | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 63.4% | | | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.1 Төлөвлөгөөт шалгалтын хамтарсан удирдамжийг боловсруулан, батлуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалтыг улсын хэмжээнд эхлүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | | 02 | 10 |
| | Дэд арга хэмжээ 2.1.2 Улсын хэмжээнд эм хангамжийн байгууллагуудад хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 100% | | 09 | 11 |
| 3. | Арга хэмжээ 2.2 Эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх | Объектын хамралтын хувь | 91% | 30% | 70% | | |
| | | Эрсдэлийн түвшин | их-30% дунд-63% | | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 64,9% | | | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.2 Сүхбаатар аймгийн 6 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдалд хяналт шалгалт хийнэ | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | | 02 | 09 |
| | | Хамралтын хувь | - | 100% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэд арга хэмжээ 2.1.3 Улаанбаатар хотод зарлагдсан 8 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | | 02 | 09 |
| | | Хамралтын хувь | - | 100% | | | |
| 4 | Арга хэмжээ 2.2. Шүдний тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт зохион байгуулна. | Хамралтын хувь | - | 50% | | 05 | 10 |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60% | | | |
| 5 | Арга хэмжээ 2.3 ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулна. | Хамралтын хувь | - | 50% | | 02 | 07 |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60% | | | |
| 6 | Арга хэмжээ 2.4 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага, стандартын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт зохион байгуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 50% | 100% | 02 | 10 |
| 7 | Арга хэмжээ 2.5 Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | - | 100% | 100% | 02 | 12 |
| | | Зөрчил арилгалтын хувь | 78.5% | 79% | 79% | | |
| 8 | Арга хэмжээ 2.6 Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 100% | 02 | 12 |
| 9 | Арга хэмжээ 2.7 Иргэн, ААН-ийн хүсэлтээр хяналтын чиглэлд хамаарах түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 100% | 02 | 12 |
| 10 | Арга хэмжээ 2.8 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээг НЭМГ-тай хамтарч хийнэ. | Үнэлгээний тайлан | - | 50% | 100% | 02 | 12 |
| | **Зорилт 3. Улсын байцаагчдын чадавхийг сайжруулна.** | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1 "2024 оны төлөвлөлт, хяналт шалгалт хийх арга зүй" сургалт зохион байгуулна. | Сургалтын тайлан | - | Сургалт хийсэн байна. | | 01 | 02 |

**Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эхний хагас жил | сүүлийн хагас | | |

| | | | | | жил | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Эмнэлгийн орчинд тархсан тэсвэржилттэй нянгийн байдалд тандалт судалгаа хийх | Судалгааны тайлан | 50% | ЭТҮХХ-ын үүсгэгч, антибиотикийн хэрэглээ, илэрсэн тохиолдлын хариу арга хэмжээний байдалд судалгаа хийх | Тандалт судалгаа хийсэн байна. | 01 | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | - | 1-ээс доошгүй | 2-оос доошгүй | 01 | 12 |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч ........................................./С.Отгонжаргал/ 2024.10.23.
(*Албан тушаал*) (*Нэр, гарын үсэг*) (*Огноо*)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Салбарын хяналтын газрын дарга ........................................./О.Энхболд/ 2024.10.29
(*Албан тушаал*) (*Нэр, гарын үсэг*) (*Огноо*)